



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/145

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.4 дэх заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дах заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт /ШШГА-ны баруун талд Нарлаг 11-03/ байршилтай иргэн Пүрэвжав овогтой Мөнхсүх /ЗЮ:84050978/-ийн Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 300 м.кв /0,03 га/ газрыг Гончигсүрэн овогтой Цэрэндаш /ЗЮ:86111010/-д зориулалтаар нь шилжүүлж 25 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/287 тоот захирамжийн иргэн П.Мөнхсүх-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000574943 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200360